

**On the issue of the nature of Mongolian people**

Darikhuu Renchin, Oyungerel Dashdorj

**Article information****Article history:**

Received: 2024.11.05

Revised: 2024. 11.18

Accepted: 2024.11.20

**Keywords:**

Human being;

Human nature;

Common characteristics to identify human nature;

Mongolian

**ABSTRACT**

Needless to say, the reform of Mongolian education in the 21st century is complicated, but there are many important goals that need to be attained and can be implemented. One of those important goals is to understand the nature of the Mongolian person and identify who they are, and subsequently elaborate, implement rational policies for the development of Mongolian citizens.

The issue of the nature of the Mongolian people is an important topic to be studied in the framework of the Mongolian education development philosophy today. This theme has a broad content and the nature of the Mongolian people has been studied to a certain extent in the scientific area of anthropology, biology, educational studies, psychology, linguistics, history, demography, and sociology in our country. However, these sciences do not consider the issue of human nature holistically/comprehensively, instead they study it in individual, specific areas. But the study of human nature in philosophy covers other aspects of humanity under its umbrella.

The study of man and his nature is one of the eternal issues of philosophy. Philosophical anthropology is an area of philosophy with theory and methods that seeks to understand the nature, or essence of human beings. Human nature is the central concept of philosophical anthropology, which comprises the fundamental characteristics that make a person human, must be developed in a person, and have a decisive effect on human life. There is a lack of philosophical research sought to study the main, defining characteristics such as, which makes a Mongolian person a Mongolian, which ought to be developed in the Mongolian people, and bring a decisive impact on the lives of the Mongolian people.

Therefore, in this brief presentation we aimed to clarify the nature of the Mongolian person based on the research of prominent philosophers Ts.Balkhaajav and N.Khavkh that studied the nature of the Mongolian person and the philosophical anthropological concepts. The concept of the nature of a Mongolian person represents a set of common characteristics that define the distinguishing qualities\ attributes of a Mongolian person. We put forward the idea that the common characteristics which define the nature of a Mongolian person should be the qualities of being intelligent, humane, hardworking, cultured, responsible and fair.

**Corresponding author:**

Darikhuu Renchin

National University of Mongolia

Email: [rdarikhuu2021@gmail.com](mailto:rdarikhuu2021@gmail.com)**Монгол хүний мөн чанарын асуудалд**

Рэнчингийн Дарьхүү, Дашдоржийн Оюунгэрэл

**Санал болгож буй эшлэл:**

Дарьхүү, Р., Оюунгэрэл, Д. (2024). Монгол хүний мөн чанарын асуудалд. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.09>

**To cite this article:**

Darikhuu, R., Oyungerel, D. (2024). On the issue of the nature of Mongolian people. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.09>

## МОНГОЛ ХҮНИЙ МӨН ЧАНАРЫН АСУУДАЛД

### ОРШИЛ

Өнөө үед ч хүн, түүний мөн чанарын талаарх асуудал дэлхий нийтэд анхаарал татсан асуудал юм. Үүнтэй холбогдуулан зарим жишээ хэлэхэд, 1988 оны 8 сарын 21-27-нд Брайтонд (Их Британи) болсон дэлхийн философийн ХҮШ их хурлын сэдэв нь хүнийг философийн төвшинд хэрхэн ойлгох тухай асуудал байсан бол, 2018 оны 8 сарын 13-20-нд БНХАУ-ын Бээжин хотод дэлхийн философийн ХХІҮ их хурал “Хүн байхад суралцахуй (Learning to Be Human)” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан. 2022 онд ЮНЕСКО дэлхийн философийн өдөр “Айсуй хүн” (The Human of the Future) сэдвийн хүрээнд хүний тухай асуудлыг хэт технологижсон өнөө үед хэрхэх вэ? маргаашийн хүн хэн байх гэх асуудлыг эргэцүүлэн тунгаахыг уриалж, симпозиум хийсэн.

Монгол Улсын боловсролын шинэчлэлд төвөгтэй боловч хэрэгжүүлэх шаардлагатай, хэрэгжүүлж болох олон чухал зорилт байгаа нь мэдээж. Тийм чухал зорилтын нэг бол монгол хүний мөн чанар, монгол хүн гэж хэн бэ гэдгийг танин мэдэж, хүнээ хөгжүүлэх оновчтой бодлого боловсруулан хэрэгжүүлэх явдал юм. Өнөөдөр монгол хүний мөн чанар, онцлогийг философийн үүднээс судалсан судалгаа хангалтгүй байгаа талаар академич Н.Бэгз “Өөрийгөө танин мэдэхүй бол өөрийгөө хөгжүүлэх урьдчилсан нөхцөл гэж философичид үздэг. Мөн хүн өөрийгөө таньж мэдэх нь философийн судалгааны эцсийн дээд зорилго хэмээн их сэтгэгч тэмдэглэжээ (Кассирер, 2016). Гэвч бид өөрийн монгол үндэстнийхээ мөн чанар, сэтгэлгээний онцлог, менталитетийг таньж мэдэх талаар тун хангалтгүй байдалтай явж ирж. Хүчирхэг хөршүүдтэй, гаднын том соёлын нөлөөнд байнга оршсоор ирсэн хүн ам цөөтэй үндэстэн монголчуудын хүмүүжил, боловсролын тогтолцоо хөгжлийн хувьд ээдрээтэй салаа замын уулзварт ирсэн өнөө үед бидэнд өөрийн гэсэн, “шинэ цаг үеийн шаардлагад тэнцэх” монгол хүнээ хөгжүүлж төлөвшүүлэх боловсролын бодлогын философи үндэслэл зайлшгүй нэхэгдэж байна.” (Бэгз Н. 2024) хэмээн дурдсан байна.

Мөн германы философич Э.Кассирерийн хэлснээр, “Өнөө үед хүнийг танин мэдэхүйд хүн өөрөө өөрийнхөө хувьд хэзээ ч ийм их асуудалтай тулгарч байгаагүй. Хүний тухай судалгаа эрхэлдэг салбар шинжлэх ухааны тоо өсөн нэмэгдэж байгаа боловч тэдгээр нь хүний тухай бодит ойлголтыг өргөжүүлэх бус, харин ч будилуулж, бүрхэгдүүлж байна. ... Хүний тухай толгой эргэм их баримт байгаа бөгөөд тэдгээрийг философи үзэл баримтлалаар эс нэгтгэвээс бид өөрсдөө зүг чигээ алдаж, хүний уг чанар, соёлын мөн чанарыг ойлгож чадахгүй.” (Кассирер Э. 2016).

Орчин үед монгол хүний мөн чанарын асуудалд иж бүрэн хандах шаардлага чухал болж, монгол хүнийг философийн үүднээс судлах, танин мэдэх хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байна. Энэ талаар философич Ж.Отгонбаяр “Хүний тухай эргэцүүлэх явдал бол философийн хувьд ямагт түлхүүр асуудал байсан. ... Философийн антропологи моодонд орлоо. Шинжлэх ухааны чиг баримжаатай хүн судлалын хүрээлэнгүүд, хүний нууц далд увидсыг илрүүлэгчид гээд, хэдийгээр үр дүн нь санасан хэмжээнд хүрэхгүй байгаа ч, “хүний эрхийн”, “хүүхдийн эрхийн”, “хүний төлөө” гэсэн тодотгол бүхий өдий төдий байгууллага хүмүүс бий болж буй нь дээрх моодны илрэл юм. Эд бүгд нэгэн цагт үр дүнгээ өгч, манай нийгэм “хүн төрхтэй” болох нь дамжиггүй.” (Отгонбаяр Ж. 2013) хэмээн тэмдэглэжээ.

Хүний мөн чанарын тухай асуудал бол ээдрээтэй бөгөөд чухал сэдэв. Дорнын болон өрнийн нэрт философичдын судалгаанд хүний мөн чанарын тухай асуудал онцгой байр эзлэдэг. Өнөөдөр манай улсад зарим иргэдэд хүн, түүний мөн чанарын талаар мэдлэг, ойлголт бага байгаагаас болж, нийгэмд үл ойлголцол, үл итгэлцэл, хүн хүнээ үзэн ядах, доромжлох, гүтгэх, хүнийг хэрэгсэл мэт хандах хандлага, элдэв төрлийн хүчирхийлэл, дарамт ихээр нэмэгдэж байна. Нийгмийн энэ гажуудлыг засаж залруулахгүйгээр хувь хүн болон нийгэм хөгжих боломжгүй. Иймд иргэдэд хүн, түүний мөн чанарын тухай мэдлэг, боловсролыг олгох, хүмүүнлэг үзэл, хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай.

Энэ тухай философич Ц.Балхаажав “Хүнээ дээдлэх, нийгмээ улам энэрэнгүй, хүмүүнлэг болгон хөгжүүлэх, улсынхаа дэвшил мандлыг шинэ, өндөр түвшинд гаргах эрхэм чухал зорилт тавьж байгаа нөхцөлд хүнээ судалж, онцлог болон нийтлэг шинжүүдийг нь тодруулж, хүний хүчийг өргөн ашиглах явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой байна. Үнэндээ монголчууд бид өөрийн түүхтэй, аж төрөх, соёл иргэншлийн өөрийн ёс заншил, зан үйлтэй, сэтгэлгээ, оюуны баялгийн зохих чадавхтайгаа ерөнхийд нь мэдэхээс бус, чухам ямар онцлог, өвөрмөц шинж, орчин нөхцөлтэй, түүндээ хэрхэн зохицож дассан хийгээд ирээдүйн манай хүнийг бие бялдар, оюун билиг, сэтгэл зүйн хувьд хэрхэн

залж чиглүүлэх тухайд мэдлэг нимгэн байна.” (Балхаажав, Ц. 2016) гэж үзээд олон жил хүний асуудлыг судалсан, олон ном бүтээл бичсэн.

## ҮНДСЭН АГУУЛГА

### НЭГ. Асуудлыг ойлгох философийн үзэл санаа

Эртнээс эдүгээ хүртэл философийн түүхэнд хүн, түүний мөн чанарын асуудлыг философийн судалгааныхаа төв асуудлаа болгодог философич олон буй. Энэ илтгэлдээ бид хүн гэж хэн болох, хүний мөн чанарын талаарх зарим философичийн үзэл баримтлалаас товчхон танилцуулж байна. Күнзийн сургаалаар, хүний мөн чанар нь эрхэм суртахуунтай, эрдэм ухаантай хүмүүн байхад оршино. Эртний грекийн нэрт философич Сократын үзлээр, “Хүн бол оюун ухаантай амьтан.” хэмээн хүний мөн чанарыг тодорхойлогч гол шинжийг оюун ухаан, мэдлэгтэй холбон тайлбарласан.

Мөн эртний грекийн нэрт философич Аристотель: “Хүнийг олон талаас харж судалж болно. Гэвч хүний гол чанар нь түүний ухаан, ёс суртахуун хоёр юм. Энэ хоёр шинж чанартай байдгаараа хүн адгууснаас гойд ялгагдана. Оюун ухааныг эзэмдсэн байх, ёс суртахуунтай байх хоёр ялгаатай. Хүн юу сайн, муу гэдгийг, юуг шударга ёс, юуг шударга бус ёс гэхэв гэдгийг ялгаж, бодож сэтгэж, хэрэглэдгээрээ адгууснаас ялгаатай. Ер нь энд л хүн байна” хэмээн хүний мөн чанарыг тодорхойлогч гол шинж нь түүний нийгмийн шинжид илүү анхаарч, хүн бол мөн чанараараа нийгмийн амьтан болох талаас судалсан.

Английн философич Т.Гоббсын үзлээр “Хүн бол байгалийн амьтан. Байгаль хүнийг биеийн болон оюуны чадварын хувьд адил тэгшээр бий болгожээ. Гэхдээ нэгэн хүн нөгөөгөөс биеийн хүчээр, ухаанаар давуу байгааг бид заримдаа ажигладаг боловч хэрэв нийтэд нь авч үзвэл тэдгээрийн хоорондох ялгаа их биш учир нэг хүн тэр ялгаагаар түрээ барьж, нөгөө хүнд хүсэвч ямар нэгэн ашиг олз олж авахын тул эрмэлзэх үндэсгүй юм.”

Хүний мөн чанар нь түүний ухаант чанар, сэтгэхүйд байдаг тухай Францын философич Р.Декарт “Би сэтгэж байгаа учраас оршин байгаа юм. Хүн бол сэтгэгч амьтан” гэсэн рационалист хандлагыг баримталсан бол, германы философич К.Маркс “Хүний мөн чанар бол бодгаль тус бүрд байдаг хийсвэр зүйл бус. Жинхэнэдээ тэрээр нийгмийн харилцааны нийлбэр цогц мөн.” хэмээн хүний хөгжилд нийгмийн ахуй, нийгмийн нөхцөл нь тодорхойлогч хүчин зүйл болно гэсэн хүний мөн чанарын тухай нийгэм төвт үзлийг баримталж байв.

Философийн хүн судлалыг үндэслэгчдийн нэг болох германы философич И.Кантын үзлээр “Хүн бол байгалийн ертөнцөд ч хамаарах, ёс суртахуун, чөлөөт байдлын хүрээнд ч хамаарах бүхэл биологийн нийгмийн амьтан бөгөөд хүн уг чанараараа хоёрдмол шинжтэй. Хүний уг чанарт нийтэч байх тэмүүлэл, хүмүүнлэг, нэр төрөө дээдлэх эрмэлзэл байдаг боловч амьтанлаг эгоизм нь муу санаалах, залилан мэхлэхэд түлхэц болж байдаг. ... Сэтгэгч амьтны хувьд өөрийн зорилгыг өөрийн оюун ухаанаар өөрөө тодорхойлогчийн хувьд зөвхөн хүн л гоо сайхан, төгс сайхны эрхэмнэл байж чадна. ... Хүний аливаа үйл ямар нэгэн ашиг хонжоог хайх бус, ёс суртахууны үүргийг ухамсарласан чөлөөт үйлдэл байх ёстой.

Тэрбээр байгаль, нийгэм гэсэн хоёр өөр ертөнцөд нэгэн зэрэг багтаж амьдардаг хүний мөн чанарыг тодорхойлогч үндсэн шинжийг ёс суртахууны чөлөөт байдал хэмээн үзсэн. И.Кантын философи дахь хүний мөн чанарын тухай гуманист үзэл баримтлалын хувьд хүн бол хамгийн дээд үнэт зүйл, хүн хүнээ хайрлах, хүндэтгэх хүндлэл хамгийн чухал билээ.

Германы философич Ф.Ницшегийн хувьд “Хүн бол бүрэн боловсорч гүйцээгүй бөгөөд амьтан-хүн хоорондын дамжлага маягийн зэрэмдэг зүйл мөн. ... Хүн бол сэтгэлийн амьтан. Хүний амьдрал бол бүхэлдээ эрх мэдэл эзэмших хүсэл эрмэлзлийн өрсөлдөөн. Хүний амьдралын үндсэн хөдөлгөгч хүч бол хувь хүний эрх мэдэлтэй байх хүсэл эрмэлзэл мөн. Хүн өөрөө өөрийгөө эзэмдэх сэтгэлийн тэнхээтэй байх, бие даасан бүтээлч сэтгэлгээтэй болох явдал хамгийн чухал байдаг.” Тэрбээр ийнхүү хүний мөн чанарыг сэтгэлийн амьтан болох талаас онцлон судалжээ.

Э.Фроммын үзлээр “Байгалийн эрхшээлээс чөлөөлөгдсөнийхөө төлөө хүн өөрийнхөө гишгэсэн алхам бүрийг сэтгэлгээ, сонголт бүхнээ хариуцах болдог. Чухам ийм хариуцлага л хүний бусад амьтнаас ялгарах жинхэнэ гол ялгаа, хүний мөн чанар юм. Тэгэхээр ихэнх хүний эрх чөлөө гэж ойлгодог, юу ч бодохгүй дур зоргоороо амьдрах хэв маяг бол адгуусны ёс байх нь. Бид хариуцлага үүрч байж л сая хүн гэгдэх эрхтэй болно.”

Индивидуалист философийн баримтлалуудыг судлах нь хүний мөн чанарыг танин мэдэхэд онол-арга

зүйн ач холбогдолтой. “Индивидуализм нь нийтийн болон хамт олны хэрэгцээ сонирхлоос хувь хүний хэрэгцээ сонирхлыг урьтал болгохыг хүлээн зөвшөөрөх байдлыг илэрхийлдэг ойлголт юм.” (Философия: Энциклопедический словарь. 2004). Индивидуалист философийн үзлээр, хувь хүн бол өөрийгөө танин мэдсэн, бие даасан эрх чөлөөтэй, хариуцлагаа ухамсарласан бөгөөд бие, сэтгэл, оюун ухааны хувьд давтагдашгүй онцлог чанарыг өөртөө агуулсан оршихуй юм. Хувь хүн бол бие даасан, ухаалаг, өөрөө өөртөө эзэн болсон хүн юм. Хувь хүний онцлог нь тухайн хүний бие, сэтгэл, оюун ухааны өвөрмөц давтагдашгүй шинжүүдийн нэгдлийг илэрхийлж буй ойлголт юм.

Ийнхүү хувь хүний онцлогийг судалж, танин мэдэх нь хувь хүний хөгжил төлөвшил болон хүмүүсийн харилцаанд чухал ач холбогдолтой. Бид хүн бүр онцгой, хүн бүр давтагдашгүй болохыг ухаарч, амьдрах шаардлагатай. Энэ зарчим нь өнөөгийн зөрчилдөөнөөр дүүрэн нийгэмд хүмүүсийн хооронд зүй зохистой, эерэг харилцааг төлөвшүүлэхэд ач холбогдолтой.

Хүн гэж хэн болох, хүний мөн чанарын тухай өгүүлсэн дээрх философи үзэл баримтлалууд нь өнгөц харахад мэдээжийн энгийн зүйл мэт боловч үнэндээ хүн гэж юу болох, хүний амьдрал үйл ажиллагааны утга учир, үнэ цэнийг тодорхойлогч нийтлэг шинжүүдийн талаар олон талаас нь харьцангуй оновчтой, гүн гүнзгий тайлбарласан болно.

### **ХОЁР. Монгол хүний мөн чанарын тухай монгол философичдын үзэл баримтлалаас**

Манай улсын хувьд философийн хүн судлалын чиглэлээр философийн мэргэжлийн эрдэмтэд, судлаачид тодорхой хэмжээнд судалгаа хийж байна. Тухайлбал, Ц.Балхаажав (Балхаажав, Ц. 2016), Б.Батчулуун (Батчулуун, Б. 1995), Б.Галиндэв (Галиндэв, Б. 2014), Р.Дарьхүү (Дарьхүү, Р. 1996), Ж.Отгонбаяр (Отгонбаяр, Ж. 2012). нарын бүтээлийг дурдаж болно. Эдгээр судлаачдын бүтээлд философи бол хүний мөн чанар руу хамгийн их дөхөж очдог мэдлэгийн тогтолцоо болох талаар, хүн гэж хэн болох, хүний мөн чанарыг танин мэдэх болон судлах философийн хүн судлалын онол-арга зүйн онцлог болон ач холбогдлыг тайлбарлажээ.

Эдгээр судлаачдаас монгол хүний төрх, монгол хүний мөн чанарын талаар философич Ц.Балхаажав, Н.Хавх нар судалгаа хийсэн байдаг. Энэхүү илтгэлдээ эдгээр философичдын үзэл баримтлалаас зарим гол үзэл санааг товчлон танилцуулж байна.

Ц.Балхаажав хүн гэж хэн болох, хүн болох, хүн байх тухай ойлголт, хүний хөгжлийн асуудал, монгол хүн хэн байсан, хэн болсон, хэн байгаа, хэн болох ирээдүйн төлөвтэй холбоотой асуудлыг философийн хүн судлалын үүднээс судлан тайлбарласан олон ном бүтээл туурвисан билээ. Түүний судалгааны онцлог нь мэргэжлийн философичийн хувьд хүний тухай цэвэр монгол сэтгэлгээний үзэл санаа байдаг оршино. Тэрбээр “Миний бага зэрэг ухаан сууж хүн болох замд орсноос хойших 70 гаруй жил ажиглаж, судлаж, ойлгож ядсаар өдий хүрсэн бөгөөд сонирхлыг минь насан туршид зогсоо зайгүй татаж ирсэн эрхэм зүйл бол Хүн сэдэв.” (Балхаажав, Ц. 2016) гэжээ.

Түүний үзлээр, “Хүнд байгалийн, нийгмийн, оюуны, өөрийн гэх дөрвөн төрөл оролцооны нэгдмэл шинж буй. ... Хүн бол хөгжил дэвшлийг аван явагч. Иймээс хүн цаг ямагт сайн сайхан руу тэмүүлж, хөгжиж дэгжиж амьдрах ёстой. Энэ нь хүн байхын бас нэгэн утга учир мөн. ... Хүн өөрөө хөгжлийн гол, аврага хүч болсон атлаа ганцхан зүйл дээр доголдож яваа. Энэ нь өөрийгөө танин мэдэхүйн хувьд дэндүү сул, дэндүү хойрго ханддаг явдал. Миний хувийн хатуу итгэл үнэмшлээр бол хүн өөрийгөө танин мэддэг болоход их анхаарал тавих нь нэн чухал буюу.”

Ц.Балхаажав 1993 онд бичсэн “Хүн та хэн бэ?” бүтээлдээ: “Хүний хөгжил бол хөдөлмөр, мэдлэг, соёл, хүмүүжил дөрвийн нэгдэл дээр тогтдог цогц үйл явц юм. Энэ дөрвийн аль нэг нь дутуу үнэлэгдвэл салшгүй цуг явагдах үйл явц доголдвол, хүний төрөлх мөн чанар сэвтэж, ноён нуруу, хүмүүнлэгийн утга учир алдагдана, хазайна, хүн болох, хүн байх арга ухаан мөхөстөнө.” (Балхаажав, Ц. 1993) хэмээн бичжээ.

Бид хүний мөн чанарын асуудлыг авч үзэхдээ хүний уг чанар буюу төрөлх чанарын ойлголтоос ялгаатай болохыг анхаарах хэрэгтэй. Хүн уг чанараараа сайн, эсвэл муу гэх, хүн уг чанараараа сайн болон муу хосолмол шинжтэй болох тухай өрнө ба дорнын философид чухалчлан судалж тайлбарласан байдаг.

Хүн гэж юу болох, монголын нийгмийн харилцаа өөрчлөгдөхөд монгол хүний төрх буюу төрөлх шинж хэрхэн өөрчлөгдөх тухай философич Н.Хавх “Монгол хүний төрх, түүний өөрчлөгдөх арга зүй” (Хавх,

Н. 2005) өгүүлэлдээ: “Хүн өөрөө нийгмийн, биологийн, сэтгэл санааны гэсэн гурван бүлэг шинжүүдийн нийлбэр цогц мөн болохоор аль нэг үндэстэн, ястан, угсаатны төрх буюу төрөлх шинж хэмээх ойлголт нь энэ бүхнийг нэгэн зэрэг багтаана. Үндэстэн, ястан, угсаатан бүр өөр өөрийн гэсэн онцлог бүхий төрхтэй” хэмээн тайлбарласан.

Мөн энэ бүтээлдээ Н.Хавх багш монгол хүний байгалиа дагасан төрх, монгол хүний дорнын онцлогтой төрхийн хувьслын талаар дэлгэрэнгүй тайлбарласан. Тухайлбал, дорно дахины хүүхэд залуучуудын унаган төрхийн нэг онцлог нь эцэг, эх, ахмад хүнийг хүндэтгэн шүтэх, тэгснээрээ тэдэнд үг дуугүй захирагдах үзэл бодол, хүмүүжил (Мөн тэнд. х. 646.) байсан бол, монгол ахмад хүний дорнын онцлогтой жинхэнэ төрх нь хүндэтгэлтэй, өндөр нэр хүндтэй, сүр бараа нөлөөлөлтэй, хүүхэд залуучуудыг авч явах чадвартай, ухаалаг буурь суурьтай, төлөв төвшин, өндөр ёс суртахуунтай байх зэрэг онцлогтой. Монгол ахмад хийгээд залуу хүмүүс ийм төрхтэй байх нь нийгэмд эдгээр хүмүүсийн гүйцэтгэх түүхэн үүргийн уялдаа авцалдааны зүй тогтлын үүднээсээ ч түүхэн гарцаагүй зүйл, “Монголчууд энэ эрин зуунд нүүдлийн соёл иргэншлээ суурьшлынхтай, нүүдлийн амьдралын явцад төлөвшсөн унаган төрхөө суурьшлын хүний төрхтэй, уламжлалаа шинэчлэлтэй хослуулан байж оршин тогтнон амьдрах, бусдын жишигт хүрч хөгжих явдал зайлшгүй зүйл.” (Хавх, Н. 2005) “Монгол хүний төрх өөрчлөгдөх үйл явц нь улиран дэвших зүй тогтолтой байна” (Мөн тэнд. х. 650) хэмээн дүгнэсэн байдаг.

Тэрбээр монгол хүний унаган төрхийг судлаад, монгол хүний төрөлх чанарын сайн талыг нь: “Нэг чигт шударга шулуун гүндүүгүй байдал, бусдыг хуурч мэхлэх, залилах явдалгүй баг үйл, бусдыг тэтгэх болон бусдаас харж хүлээж хүсэх хиргүй тунгалаг сэтгэл, ах зах дээд хүмүүст үзүүлэх сэтгэлээ дагасан хүндэтгэл, бусдыг сэтгэлээрээ шууд мэдрэн таних онцгой чадвар, өрөвч зөөлөн харимтгай сэтгэл, бусадтай хиргүй цагаан сэтгэлээр харьцах харьцаа, сэтгэл санааны их эрч хүч, эрмэлзэл тэмүүлэл” хэмээн тодорхойлсон буй.

Н.Хавх монгол хүний төрөлх чанарын муу талыг нь: “Өрх гэрийн хүрээнд ураг төрлийн хүмүүсийн харьцаагаар бий болсон хязгаарлагдмал үзэл бодол нь өөр хүрээлэлд таарч тохирохгүй болоод ирэхлээр хямардаг, түүнээс гарахын тулд тэр үедээ тархи толгойгоо эрч далайцтай ажиллуулна, ухаан бодлоо сийлнэ, тэр хэрээр хурдан түргэн хямралаас гарах арга замыг олно; харин энэ хооронд үе үе туйлширна, өрх гэрийн хүрээнд төлөвшин бий болсон үзэл бодол, шинж, унаган төрхөөсөө огцом эрс ухарч, бусдыг дуурайн, тэднийг аялдан дагаж хошуурна, эс дагагсдыгаа хавчиж шахна, овжин зальтай, хуурч мэхлэх, итгэл алдуулах, хувиа хичээх явдлыг чухалчлан сонирхоно, залуус нь эцэг эх, ахмад үетэйгээ, эхнэр нь эр нөхөртэйгөө эвдрэлцэж, тэд нь ч үр хүүхэд, залуу үе, эхнэртээ итгэх итгэлээр тааруу болно” хэмээн дүгнэсэн байна.

Ц.Балхаажав, Н.Хавх нарын судалгааны бүтээлүүдэд монгол хүн, түүний мөн чанарын асуудлаар олон чухал философи үзэл санаа дэвшүүлсэн нь монгол хүн өөрийгөө танин мэдэхэд чухал ач холбогдолтой.

### **ГУРАВ. Монгол хүний мөн чанарын талаарх эргэцүүлэл**

Монгол хүний хөгжлийн байдал, философийн хүн судлалын үзэл баримтлал, монголын философичдын үзэл баримтлалд үндэслэн Монгол хүний мөн чанарыг тодорхойлогч гол шинжүүд нь ухаалаг, хүнлэг, хөдөлмөрч, хариуцлагатай, шударга байх гэж бид үзэж байна.

Хүнийг ухаалаг амьдар гэж оюун ухаан заяасан билээ. Монгол хүний ухаалаг байх шинжид эрүүл саруул ухаан, монголчуудын уламжлалт мэдлэг, ухаан болон орчин үеийн мэдлэг боловсролыг хослуулан суралцах, холч ухаантай байх, бүтээлч сэтгэлгээтэй байх, бие даан сэтгэх чадвартай байх, уужуу ухаантай байх, агаа жөтөө, хэт шуналаас ангид байх, асуудлыг уураар биш, ухаанаараа шийдэх зэрэг чадвар хамаарна.

Хүнийг хүн болгодог, хүний мөн чанарыг тодорхойлогч гол шинжийн нэг бол хүнлэг ёс, хүн чанар юм. Монгол хүний хүнлэг хүн байх шинжид хүнийг хүн ёсоор үзэх, өөрийгөө болон бусад хүнийг хүндэтгэх, хайрлах, халамж анхаарал тавих, бусдын санаа сэтгэлийг ойлгох, хүлээцтэй хандах, эелдэг эвсэг байх, хүн хүндээ найз нөхөр, ах дүү байх, хүн хүндээ туслах, өөрийн болон бусад хүний нэр төрийг хайрлах, бусдын төлөө гэх сэтгэлтэй байх, бусдыг алагчлах үзлээс ангид байх, хэт аминч үзлээс ангид байх, сэтгэлийн тэнхээтэй байх зэрэг чадвар хамаарна.

Хүн нийгэм хоёр салшгүй холбоотой нийгэмд амьдрахын тулд хүнд эн тэргүүнд байх ёстой бөгөөд хүний мөн чанарыг тодорхойлогч нийтлэг шинжийн нэг бол хөдөлмөрч байх явдал билээ. Монгол хүний хөдөлмөрч хүн байх шинжид ажилсаг, хөдөлмөрийн үнэ цэн, ач холбогдлыг ойлгох, мэргэжилдээ үнэнч

байх, мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх, ажил мэргэжилдээ эзэн байх чадвар, ажлынхаа чанар, үр дүн, ашиг тусыг чухалчлах зэрэг чадвар хамаарна.

Соёл нь хүнийг бусад амьтнаас ялгах, хүний мөн чанарыг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл мөн. Монгол хүний соёлтой хүн байх шинжид эх хэлний мэдлэг, монголчуудын болон хүн төрөлхтний үнэт зүйлсээс тасралтгүй суралцан эрхэмлэн дээдлэх, бүтээлч байх, харилцааны соёлтой байх, нийтэч нийлэмжтэй байх зэрэг чадвар хамаарна.

Хариуцлага нь хүний мөн чанарыг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл мөн. Монгол хүний хариуцлагатай хүн байх шинжид хамаарах чадамжийн агуулгад хэлсэндээ хүрдэг байх, найдвартай хүн байх, цаг баримтлах, өөрийн эрх, үүргээ ухамсарласан, идэвх санаачилгатай байх, ичих эмээх мэдрэмжтэй байх, хашир хянамгай байх, худлаа ярихгүй, хоосон амлахгүй байх, бусдад сайнаар үлгэр дуурайлтай байх зэрэг чадвар хамаарна.

Шударга байдал нь хүний мөн чанарыг тодорхойлогч чухал үнэт зүйл мөн. Монгол хүний шударга хүн байх шинжид аливаа үйлдэл, харилцаанд тэгш байдлыг эрхэмлэх, зөвийг эрхэмлэх, сайн үйл хийх, шударга бус зүйлтэй эвлэрэхгүй байх, ямар ч тохиолдолд ёс суртахуунлаг байх зэрэг чадвар хамаарна.

Энэ бүхнээс дүгнэн хэлэхэд, манай боловсролын шинэчлэлд монгол хүний мөн чанарын асуудлыг олон талаас сайтар анхааран судалж, бүх шатны сургалтын агуулгад гүн гүнзгий тусган оруулах нь зүйтэй.

## ДҮГНЭЛТ

Хүний мөн чанарын тухай асуудал философи болон шинжлэх ухааны аль алинд ямагт гол асуудлын нэг байсаар ирсэн. Хүний мөн чанарын асуудал бол олон талтай, ээдрээтэй асуудал байдаг тул энэ асуудлыг хүн бол сэтгэлийн амьтан, хүн бол оюун ухаант амьтан, хүн бол байгалийн амьтан, хүн бол нийгмийн амьтан гэх зэргээр ганц талаас асуудлыг авч үзэж, тайлбарлах боломжгүй.

Монгол хүний мөн чанарын асуудлыг танин мэдэх, судлахад тавигдах философийн хүн судлалын арга зүйн гол шаардлага бол энэ асуудлыг иж бүрэн цогц байдлаар судлах явдал мөн.

Иймд цаашид монгол хүн гэж хэн бэ гэдэг асуудлыг, монгол хүний мөн чанарыг тодорхойлохын тулд философи, боловсрол судлал, сэтгэл судлал, хүн судлал, биологи, анагаах ухаан зэрэг хүнийг судалдаг олон салбарын эрдэмтэд ул суурьтай хамтран иж бүрэн суурь судалгаа хийж, төрөөс баримтлах бодлогод тусган хэрэгжүүлэх, иргэдэд энэ асуудлаар тодорхой үнэн зөв мэдлэг, боловсрол олгоход онцгой анхаарах хэрэгтэй.

Монголын боловсролын нэг гол зорилго нь монгол хүнийг хөгжүүлэх асуудал билээ. Тэгвэл монгол хүний хөгжлийн асуудал нь монгол хүний мөн чанарыг судлан шинжлэхээс ангид байж болохгүй.

## Эшлэл авсан ном зүй

Балхаажав, Ц. (2016). Хүн алдрын гайхамшиг. Хүнийг үзэх үзлийн эрдэм шинжилгээний цуврал гурван боть. Улаанбаатар.

Балхаажав, Ц. (1993). Хүн та хэн бэ? Улаанбаатар.

Бэгз, Н. (2024). Монгол хүн гэж хэн бэ, түүний хөгжлийн философи үзэл санааг хэрхэн томъёолох вэ? - // Боловсрол судлал сэтгүүл. Vol. 204 No. 6. Улаанбаатар.

Кассирер, Э. (2016). Хүний тухай судалгаа. Хүний соёлын философийн удиртгал. Хүний тухай философи. Улаанбаатар.

Отгонбаяр, Ж. (2013). Хүний философийн зарим асуудал- Философи, эрх зүйн боловсрол. Сэтгүүл. №6. Улаанбаатар.

Хавх, Н. (2005). Монгол хүний төрх, түүний өөрчлөгдөх арга зүй – //Н.Хавх. Социологи, монголын нийгмийн гүн ухааны зарим чиглэлүүд. Улаанбаатар.

Философия: Энциклопедический словарь. (2004). Под редакцией А.А. Ивина. Москва.